МОНГОЛ-ОРОСЫН
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 09 сарын 11 өдөр Дугаар А/802 Улаанбаатар хот

Галын аюулаас урьдчилан сэргийлэх
ажлыг эрчимжүүлэх тухай

Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 106 дугаар, 2016 оны 339 дүгээр тогтоол, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын дүрмийн 22 дугаар зүйлийн "а" заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "УБТЗ" ХНН-ийн хэмжээнд объектын болон ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор "УБТЗ-ын Гал түймэртэй тэмцэх комиссын бүрэлдэхүүн"-ийг 1 дүгээр хавсралт, "УБТЗ-ын Гал түймэртэй тэмцэх комиссын ажиллах журам"-ыг 2 дугаар хавсралт, "УБТЗ-ын Гал түймэртэй тэмцэх комиссын бүрэлдэхүүн, алба, хэлтэс, төв, тасаг, салбар нэгжийн дарга нарын үүрэг"-ийг 3 дугаар хавсралт, "Төлбөрт үйлчилгээ хийх журам"-ыг 4 дүгээр хавсралт, "Төлбөрт үйлчилгээ хийх үнэ тариф"-ыг 5 дугаар хавсралт, "Алслагдсан өртөө зөрлөгийн нутаг дэвсгэрт ой, хээрийн болон объектын түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэхэд зайлшгүй шаардлагатай багаж, хэрэгслийн жагсаалт"-ыг 6 дугаар хавсралт, "Алба, хэлтэс, төв, салбар нэгжийн ажилтны галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр эзэмшвэл зохих сургалтын хөтөлбөр"-ийг 7 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг гал түймэртэй тэмцэх комисс, алба, хэлтэс, төв, салбар нэгжийн дарга нарт даалгасугай.

3. Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албанд шаардлагатай мэргэжлийн боловсон хүчин бэлдэх асуудлыг тус албаны саналыг харгалзан Замын сургалтын төлөвлөгөөнд жил бүр тусган өгч шийдвэрлэж байхыг Хүний нөөцийн албанд даалгасугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Тээврийн хяналтын алба, Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын алба хариуцсан байцаагч, чиглэл хариуцсан албадын байцаагч нарт даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар төмөр замын даргын 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А-306 дугаар тушаалыг хүчингүй болгосонд тооцсугай.

НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ ДАРГА О.А. КАЗАКОВ

1601234484

"УБТЗ" ХНН-ийн даргын 2023 оны 09 дугаар
сарын 11-ны өдрийн .....А/802..... дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

УБТЗ-ЫН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Комиссын дарга:
   Замын ерөнхий инженер

2. Комиссын орлогч дарга
   Хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан замын орлогч дарга

3. Комиссын нарийн бичгийн дарга
   1. Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны орлогч дарга
   2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн албаны орлогч дарга

4. Комиссын гишүүд:
   - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн албаны дарга
   - Суурь бүтэц хариуцсан замын орлогч дарга
   - Замын ерөнхий инженерийн орлогч дарга
   - Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны дарга
   - Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны галын ахлах байцаагч
   - Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга
   - Төлөвлөлт, эдийн засгийн албаны дарга
   - Замын аж ахуйн албаны дарга
   - Тээвэр зохион байгуулалтын албаны дарга
   - Зүтгүүрийн аж ахуйн албаны дарга
   - Вагоны аж ахуйн албаны дарга
   - Дохиолол, холбооны албаны дарга
   - Худалдан авах ажиллагаа, борлуулалтын албаны дарга
   - Эрчим хүч, ус хангамжийн төвийн дарга
   - Барилга, орон сууцны албаны дарга
   - Их барилга, хөрөнгө оруулалтын албаны дарга
   - Тээврийн хяналтын албаны гал, харуул хамгаалалт хариуцсан хяналтын байцаагч

- oOo -

"УБТЗ" ХНН-ийн даргын 2023 оны 09. дугаар
сарын 11.-ны өдрийн .....А/802..... дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

УБТЗ-ЫН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ КОМИССЫН
АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Зорилго

1. УБТЗ-ын Гал түймэртэй тэмцэх комиссын /цаашид Комисс гэх/ ажиллах журам нь гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө, төсөв, зохион байгуулалт, хэрэгжүүлэх арга хэмжээ, гарсан гал түймрийн хэрэг, зөрчлийн талаар авах арга хэмжээ, гал түймрийн шалтгаан нөхцөл, түүнийг арилгах, давтан гаргахгүй байх талаар төлөвлөж, шийдвэр гаргах, сахилгын хариуцлага тооцох үйл ажиллагааг зохицуулахад оршино.

Хоёр. Комиссын ажлын дараалал

2.1. Замын хэмжээнд хэрэгжүүлэх гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг баталж, жил бүрийн их барилга, их засвар, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэх хуралд урьдчилан сэргийлэх ажлын төсвийг оруулж батлуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах.

2.2. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 дах заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дах заалтын дагуу гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1,5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөн, төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах.

2.3. Мэргэжлийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар "Нарийвчилсан гал түймрийн эрсдэлийн үнэлгээ" хийлгэх салбар нэгжийн жагсаалтыг хэлэлцэж батлан үнэлгээг хийлгэнэ.

2.4. Комиссын бүрэлдэхүүн салбар нэгжид хуваариар хяналт тавьж, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах.

2.5. Комисс жил бүрийн хагас, бүтэн жилд 1 удаа, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний биелэлт, тайланг хэлэлцэж, шийдвэр гаргах.

2.6. Замын хэмжээнд гал түймэр, байгалийн давагдашгүй хүчин зүйл, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан нэмэлтээр шаардагдах зардлын асуудлыг комисс хуралдаж, замын удирдлагад танилцуулан шийдвэрлүүлж ажиллах.

2.7. Алба, хэлтэс, төвүүд төлөвлөгөөний биелэлт, тайланг улирал бүрээр нэгтгэн дараа сарын 20-ний дотор комисст ирүүлнэ.

2.8. Комиссын нарийн бичгийн дарга алба, хэлтэс, төвүүдийн тайлан, мэдээ, төлөвлөгөөний биелэлтийг нэгтгэн дүгнэж, дүнг комисст танилцуулж ажиллах.

Гурав. Хурал зохион байгуулах

3.1. Гал түймэртэй тэмцэх комиссын хуралдааныг комиссын дарга төлөвлөгөөт болон цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан зарлан хуралдуулна. Нарийн бичгийн дарга хурлын бэлтгэл ажлыг хангаж ажиллана.

3.2. Комиссын хурлыг шуурхай зарласан даруйд ЦХОБА-ны диспетчерээр дамжуулан шуурхай тушаал өгч зарлалыг цахимаар тарааж комиссын бүрэлдэхүүнд мэдэгдэж ажиллана.

3.3. Комиссын дарга, гишүүд хүндэтгэн үзэх шалтгаантайгаар комиссын хуралд оролцох боломжгүй нөхцөлд орлон оролцсон алба, хэлтэс, төв, салбар нэгжийн эрх бүхий албан тушаалтан хурлаас гаргасан шийдвэрийг комиссын жинхэнэ гишүүнд танилцуулна.

3.4. Хурлын танхимыг Замын даргын ажлын алба хариуцаж бэлтгэнэ.

3.5. Цахимаар хийгдэх хурлыг Статистик бүртгэл мэдээллийн алба хурлын линк үүсгэж, комиссын бүрэлдэхүүн, хуралд оролцогсдод шуурхай хүргэх ажлыг зохион байгуулна.

3.6. Комиссын хурлыг салбар нэгжүүдийн төлөөллийг оролцуулан өргөтгөсөн хэлбэрээр зохион байгуулж болно.

3.7. Комисс хуралдаад хэсэгчилсэн хяналт шалгалтыг хийх ажлын хэсгийг томилж ажиллуулж болно.

Дөрөв. Комиссын шийдвэр

4.1. Комиссын бүрэлдэхүүн хурлаас гаргасан шийдвэрийг хэрэгжилтэд хяналт тавьж, алба, хэлтэс, төв, салбар нэгжийн удирдлагууд биелэлтийг хангаж ажиллана.

Тав. Хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэл гаргасан ажилтнуудад хариуцлага тооцно.

5.2. Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй үйлдэлд эрх бүхий байгууллага, захиргааны дутагдалд комисс хариуцлага тооцох саналыг гаргаж, шийдвэрлүүлнэ.

Зургаа. Шагнал, урамшуулал

6.1. Галын аюулаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажилд идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж бусдыгаа хошуучилсан салбар нэгж, удирдлага, ажилтныг шагнаж, урамшуулна.

- o0o -

"УБТЗ" ХНН-ийн даргын 2023 оны 09 дугаар
сарын 11 -ны өдрийн А/802 дугаар
тушаалын 3 дугаар хавсралт

УБТЗ-ЫН ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН, АЛБА, ХЭЛТЭС, ТӨВ, ТАСАГ, САЛБАР НЭГЖИЙН ДАРГА НАРЫН ҮҮРЭГ

Нэг. Гал түймэртэй тэмцэх комиссын даргын үүрэг

1.1. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 заалтын дагуу гал түймрийн эрсдэлийн үнэлгээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтарч хийлгэх, жил бүр объектын болон ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг баталж, комиссын бүрэлдэхүүнийг удирдлагаар хангаж, биелэлт үр дүнг тооцож ажиллах.

1.2. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Замын хэмжээнд ой хээр, объектын түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, унтраах, шаардлагатай техник, багаж хэрэгслийг худалдан авах зардлыг хуульд заасан нэр томьёогоор төлөвлөн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

1.3. Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны стратегийн төлөвлөгөөнд заагдсаны дагуу тус албанд шаардагдах галын автомашин, техник тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчлэх ажлыг санаачлан зохион байгуулах.

1.4. Ой хээр, объектын түймрээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах талаар 03 дугаар сарын 20-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэлх түймрийн аюултай, хуурайшилтын улиралд Замын хэмжээний зөвлөгөөн зохион байгуулж, цаг үеийн онцлогтой уялдуулан үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах.

1.5. Комиссын гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, үнэлэлт, дүгнэлт өгч цаашид авах ажил, арга хэмжээг зохион байгуулах.

1.6. Алба, хэлтэс, төв, салбар нэгжийн удирдах ажилтны /дарга, орлогч, ерөнхий инженер/ сургалтыг мэргэжлийн байгууллагатай хамтарч Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын алба зохион байгуулахад удирдлагаар хангаж ажиллах.

1.7. Цаашид энэ төрлийн урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөгөөт болон төлөвлөгөө бус хурал дээр ажлын үр дүнг хэлэлцэх.

Хоёр. Гал түймэртэй тэмцэх комиссын орлогч даргын үүрэг

2.1 Гал түймэртэй тэмцэх комиссын даргыг эзгүй байх хугацаанд комиссын даргын үүргийг орлон гүйцэтгэнэ.

Гурав. Гал түймэртэй тэмцэх комиссын нарийн бичгийн даргын үүрэг

3.1 Гал түймэртэй тэмцэх комиссын үндсэн нарийн бичгийн дарга нь Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны орлогч дарга байна, түүнийг эзгүй байх хугацаанд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн албаны орлогч дарга үүргийг орлон гүйцэтгэнэ.

3.2 Гал түймэртэй тэмцэх комиссын ажиллах журмын хэрэгжилтийг хангуулж ажиллана.

3.3 Нарийн бичгийн дарга нь хурлын тэмдэглэл бичих, хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг хангуулж ажиллана.

3.4 Чиглэлийн дагуу ирж байгаа мэдээ, мэдээллийг танилцуулах, тайлан нэгтгэх, холбогдох мэдээ мэдээллээр комиссын дарга, гишүүдийг хангах үүргийг гүйцэтгэнэ.

Дөрөв. Алба, хэлтэс, төвийн дарга нарын үүрэг:

4.1. Хариуцсан алба, хэлтэс, төв нь энэхүү журмын хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөө гаргаж, биелэлтийг хангах ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож, комисст тогтоосон хугацаанд тайлан мэдээг хүргүүлэх бөгөөд ажил сайжруулах чиглэлээр саналаа тусгасан байна.

4.2. Байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг байгуулахдаа Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолын 2.17-д заасны дагуу ажлыг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

4.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн 3 дугаар шатны үзлэг, объект дээр хийгдсэн аюулгүйн өдөр, гэнэтийн эргүүл шалгалтаар илэрсэн галын аюулгүй байдалтай холбоотой дутагдлыг засуулах арга хэмжээг зохион байгуулах.

4.4. Гарсан гал түймрийн нөхцөл байдал, учирсан хохирлын талаар мэргэжлийн албадын хамтарсан комисс тогтоосон актыг урьдчилсан байдлаар гаргуулж, комисст танилцуулна.

4.5. Ой хээрийн түймрийг унтраах хүн хүч, автомашин техник, түймэр унтраах багаж хэрэгслээр хангах, ажлыг зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангах, мэргэжлийн байгууллага /орон нутгийн засаг захиргааны нэгж, онцгой байдал, цагдаа/-д мэдэгдэх.

4.6. Гал унтраах ажилд оролцсон Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны хүн хүч, техник хэрэгслийн холбогдох зардлын нэхэмжлэлийг барагдуулах арга хэмжээг авах.

4.7. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.2 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 заалтын дагуу гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1,5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөн, төсөвт тусгуулах ажлыг зохион байгуулах, зориулалтын дагуу зарцуулж ажиллах.

4.8. Байгууллагын хэмжээнд гал түймрийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх саналаа улирал бүр комиссын нарийн бичгийн даргад ирүүлэх.

Тав. Замын аж ахуйн албаны даргын үүрэг: (П)

5.1. Ойн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 заалтын дагуу төмөр замын, хот хоорондын зам, иргэдийн өвөлжөө, хаваржаа, үтрэм, тариалангийн талбай, ой дахь барилга, байгууламжид ой хээрийн түймрийн хамгаалалтын шороон зурвас хийлгэж, хүлээн авах.

5.2. Төмөр замын аюултай бүсийн торон хашаан доторх шатах материал, өвс ургамал, бут сөөгийг зайлуулах, цэвэрлэх хадах, шороон зурвас татах ажлыг зохион байгуулах, зайлшгүй тохиолдолд шатаах арга хэрэглэх, Онцгой байдлын албанд мэдэгдэж зөвшөөрөл авч, хяналт тавин ДГ, ДГП, ВОХРд-д тус тус мэдэгдэж ажиллах.

5.3. Төмөр зам дагуу өвс ургамлыг цэвэрлэх аргад техник технологийн дэвшилтэд арга /байгаль экологид сөрөг нөлөөгүй ургамал ургуулахгүй байх бодис, бусад материал гэх мэт/ ажиллагааг хэрэглэх.

5.4. Ажилтнуудыг хуурайшилтын улиралд ой, хээрийн түймрийн эргүүлийн ажлыг хавсарган гүйцэтгүүлж сарын ажлын үр дүнгээр шагнал олгоход харгалзах үзүүлэлт болгон ажиллах.

5.5. Ой хээрийн түймрийг унтраах хүн хүч, автомашин техник, түймэр унтраах багаж хэрэгслээр хангах, ажлыг зохион байгуулж нэгдсэн удирдлагаар хангах, мэргэжлийн байгууллага /орон нутгийн засаг захиргааны нэгж, онцгой байдал, цагдаа/-д мэдэгдэх.

5.6. Мод бэлтгэх, ойн арчилгаа, цэвэрлэгээ хийх тохиолдолд талбайн үлдэгдэл, хаягдлыг цэвэрлэхдээ шатаах аргыг хэрэглэхгүй байх. Гарсан үлдэгдлийг овоолох, далан хэлбэрээр хураах, бутлан жижиглэх, өвлийн улиралд мод бэлтгэл, огтлолт явуулсан тохиолдолд талбайн цэвэрлэгээг хавар дахин хийж гүйцэтгэх.

5.7. Төмөр зам дагуу хатсан өвс ургамлыг цэвэрлэх аргад техник технологийн шинэлэг хэрэгсэл ашиглах, дэвшилтэд арга /байгаль экологид сөрөг нөлөөгүй ургамал ургуулахгүй байх бодис, бусад материал, техник гэх мэт/ ажиллагааг хэрэглэх.

5.8. Ой хээрийн болон объектын галын аюулаас урьдчилан сэргийлэх, түймрээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах талаар жил бүрийн хавар (03 дугаар сарын 20-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл), намар (09 дүгээр сарын 20-ний өдрөөс хэлэн 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл) улирлын хугацааг түймрийн аюултай үе гэж үзэн хуурайшилтын улиралд хамгаалалтын шороон зурвас татах, хуучин зурвас газрыг сэргээх арга хэмжээг авч ажиллана.

5.9. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж, объект бүрд байрлуулж, ашиглалтын бэлэн байдал хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгаж засварлах арга хэмжээг авч ажиллах.

Зургаа. Т, НГС, ЭВ, Ш алба, төвийн дарга нарын үүрэг:

6.1. Ой хээрийн түймэр гарах эрсдэлтэй газар байрлах цахилгаан шугам сүлжээ байгууламжид засвар үйлчилгээ хийхдээ галын аюулгүй байдлыг хангаж,

ойр орчмын шатах материал өвс ургамлыг цэвэрлэх ажлыг тогтмол зохион байгуулж хяналт тавих.

6.2. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3 заалтын дагуу цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг шинэчлэх, өөрчлөх, засварлахдаа эрх бүхий мэргэжлийн байгууллагаар магадалгаа хийлгэсэн зураг төслийн дагуу гүйцэтгэх.

6.3. Цахилгаан шугам татах, засварлах ажлыг гүйцэтгэх байгууллага нь хуурайшилтын үед түймрийн аюулгүй байдлыг хангаж, гал унтраах багаж хэрэгслийг бэлэн байлгах.

6.4. Түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах зориулалттай усан сан, худгийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх, гал унтраах тусгай зориулалтын галын галт тэрэг, автомашин, техник хэрэгслийн шуурхай усаар зэхэх нөхцөл сайжруулах ажлыг төлөвлөгөөтэйгөөр жил бүр зохион байгуулах.

6.5. Гал унтраах зориулалтын гадна, дотор шугам сүлжээ, галын гидрантад хавар намрын хуурайшилтын улирлын өмнө, гал түймэр унтраах, аврах ангийн гал унтраах зориулалтын автомашиныг оролцуулан шалгаж бэлэн байдлыг хангуулах.

6.6. Барилга байгууламжийн цахилгаан тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралтыг Цахилгаан байгууламжийн дүрэм, цахилгааны угсралт, ашиглалтын техникийн шаардлага, дүрмийг мөрдөж угсралт, засвар үйлчилгээг хийж, байгууллагын цахилгаанчин нарт мэргэжлийн зөвлөгөө дэмжлэг үзүүлж ажиллах.

6.7. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж, объект бүрд нормын дагуу бүрдүүлэн байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгаж засварлах арга хэмжээг авч ажиллах.

6.8. Байгууллагадаа гал түймрийн хэрэг зөрчил, гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн бүртгэл, судалгааг хөтөлж материалжуулах.

6.9. Барилга байгууламжид ашиглагдаж байгаа барилгын материалын зардлыг тооцохдоо итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй гал тэсвэртэй зэрэглэл өндөр стандартын ШҮ - шатдаггүй, Ш - шатдаг ангиллын Ш1 - бага зэрэг шатдаг ангилалд хамаарах материалаар тооцож, төсөвт тусгаж ажиллах.

6.10. Хавар намрын хуурайшилтын үе эхлэхээс өмнө цахилгаан дамжуулах, холбооны модон шонгийн доор хуримтлагдсан шар өвс шатамхай материалыг эргэн тойронд 2 метрээс доошгүй хэмжээтэй цэвэрлэж, усан сан, худгийн тоо түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлж ажиллах.

Долоо. Тээвэр зохион байгуулалтын албаны даргын үүрэг: (Д)

7.1. Хавар, намрын хуурайшилтын улирлын үед өртөө, зөрлөгийн чанга яригчаар галт тэрэг, ирэх, явах үед ухуулга сурталчилгааг тогтмол явуулж байх.

7.2. Хуурайшилтын улирлын үед ой хээрийн түймэр төмөр замын хамгаалалтын торон хашаан дотор орж ирсэн мэдээлэл авсан үед түүгээр аюултай ачаа болон тэсэрч дэлбэрэх ачааг дамжин өнгөрүүлэхгүй байхаар төмөр замын ачаа, зорчигч тээврийн үйл ажиллагааг зохион байгуулах.

7.3. Хавар, намрын хуурайшилтын улирлын өмнө төмөр замын хамгаалалтын торон хашаан доторх өвс ургамлыг дэвшилтэд технологи ашиглан цэвэрлэх ажлыг замын анги, хэсэг, тасгууд зохион байгуулж буй үеэр диспетчерийн мэдээллийн дагуу аюултай ачаа болон тэсэрч дэлбэрэх ачааг дамжин өнгөрүүлэхгүй байхаар зохион байгуулах.

7.4. Суурин газрын төмөр замын хамгаалалтын торон хашаан доторх өвс ургамал, бут сөөгийг зайлуулах, цэвэрлэх, хадах зэрэг арга хэмжээг зангилаа, өртөөний салбар нэгжийн ажилтнуудын хүчийг оролцуулан хийх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах.

7.5. Өртөө зөрлөгийн паркийн зам, перроны орчмын иргэд олноор цугларах газруудад гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзүүлэн сурталчилгааны самбар байрлуулах.

7.6. Гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж, объект бүрд нормын дагуу бүрдүүлэн байрлуулж, ашиглалтын бэлэн байдлыг хангаж байгаа эсэхэд хяналт тавьж, үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгаж засварлах арга хэмжээг авч ажиллах.

7.7. Барилга байгууламжид ашиглагдаж байгаа барилгын материалын зардлыг тооцохдоо итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй гал тэсвэртэй зэрэглэл өндөр стандартын ШҮ - шатдаггүй, Ш - шатдаг ангиллын Ш1 - бага зэрэг шатдаг ангилалд хамаарах материалаар тооцож, төсөвт тусгаж ажиллах.

Найм. Их барилга, хөрөнгө оруулалтын албаны даргын үүрэг: (НКС)

8.1. Барилга орон сууцны эзэмшилтэд хяналтын байгууллагатай хамтарч үзлэг шалгалтыг эзэмшигч байгууллагын захиалгаар хийж гүйцэтгэнэ.

8.2. Цахилгаан шугам сүлжээг буруу ашиглах, барилгын хийц бүтцийг дур мэдэн өөрчлөх, хортой ба тэсэрч дэлбэрэх, муухай үнэртэй бодис материал хадгалах, гал түймэр гаргах зэргээр хүний амь нас, амгалан тайван амьдрах нөхцөлийг алдагдуулах, инженерийн шугам сүлжээ, сантехникийн систем, тоног төхөөрөмжийг эвдэж гэмтээх зэрэг хохирол учруулж болзошгүй албан газарт захиалгын дагуу, хамтарсан үзлэг шалгалт хийж шаардлага тавьж зөрчлийг арилгах.

8.3. Үйлдвэр, аж ахуйн нэгжийн ажлын байранд шинээр халаалтын зуух суурилуулах, төрөл бүрийн халаах хэрэгслээр тоноглох, барилга байгууламж шинээр барих, өргөтгөх, засварлахдаа Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.3 заалтын дагуу магадалгаа хийлгэсэн зураг төслийн дагуу мэргэжлийн байгууллагад хандаж дүгнэлт гаргуулж гүйцэтгэх.

8.4. Их барилга, их засварын ажлын төлөвлөгөөгөөр хийгдэж байгаа жил бүрийн шинээр барих, өргөтгөл, засварын ажилд галын аюулгүй байдлыг хангах талаар төсөв төлөвлөгөөнд галын аюулгүй байдлын тодорхойлсон стандарт норм дүрмийн хэрэгжилтийг хангуулах талаар тусгаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

8.5. Барилга байгууламжид ашиглагдаж байгаа барилгын материалын зардлыг тооцохдоо итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй гал тэсвэртэй

зэрэглэл өндөр стандартын ШҮ - шатдаггүй, Ш - шатдаг ангиллын Ш1 - бага зэрэг шатдаг ангилалд хамаарах материалаар тооцож, төсөвт тусгаж ажиллах.

Ес. Зураг төслийн төвийн даргын үүрэг: (НДП)

9.1. Барилга байгууламж, техник, тоног төхөөрөмж, цахилгааны шугам сүлжээг шинээр барих, өргөтгөх болон хийц бүтэц, цахилгааны эх үүсвэрийн шугам сүлжээг өөрчлөх, засварлах ажлын зураг төсөлд галын аюулгүй байдлыг тодорхойлсон стандарт норм, норматив баримт бичгийн хэрэгжилтийн хангуулан боловсруулж, эрх бүхий иргэн, хуулийн этгээдээр магадалгаа хийлгэж, Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагаар хянуулан зөвшилцөх, баталгаажуулах арга хэмжээг авч, батлагдсан зураг төслийн дагуу ажил гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавьж ажиллах.

9.2. Барилга байгууламжид ашиглагдаж байгаа барилгын материалын зардлыг тооцохдоо итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй гал тэсвэртэй зэрэглэл өндөр стандартын ШҮ - шатдаггүй, Ш - шатдаг ангиллын Ш1 - бага зэрэг шатдаг ангилалд хамаарах материалаар тооцож, төсөвт тусгаж ажиллах.

Арав. Төлөвлөлт, эдийн засгийн албаны даргын үүрэг: (НН)

10.1. Гамшиг осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх, болзошгүй гамшиг осол, гал түймэртэй тэмцэх зардлыг төсөв захиран зарцуулах эрхтэй алба, хэлтэс, төв, салбар, нэгжүүдэд Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 заалтын дагуу гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1,5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөн, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

10.2. Эрсдэлийн үнэлгээг үндэслэн төсөв захиран зарцуулах эрх бүхий салбар, нэгжид галын аюулаас урьдчилан сэргийлэх эрсдэлийг бууруулах төсвийн төлөвлөгөөг зөвшилцөж олгож ажиллах.

Арван нэг. Баянтүмэн тасгийн даргын үүрэг: (НОД)

11.1. Ойн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 заалтын дагуу төмөр замын, хот хоорондын зам, иргэдийн өвөлжөө, хаваржаа, үтрэм, тариалангийн талбай, ой дахь барилга, байгууламжид ой хээрийн түймрийн хамгаалалтын шороон зурвас, хийлгэж, хүлээн авах.

11.2. Төмөр замын хоёр талын хамгаалалтын торон хашаан доторх шатах материал, өвс ургамал, бут сөөгийг зайлуулах, цэвэрлэх хадах, зурвас татах ажлыг жил бүр зохион байгуулалттай ажил болгон хэрэгжүүлж, зайлшгүй тохиолдолд шатаах арга хэрэглэх шаардлагатай үед суурин газраас бусад хоорондын төмөр зам дагуу хамгаалалтын торон хашаан доторх өвс ургамлыг намрын улиралд орон нутгийн Онцгой байдлын албанд мэдэгдэж зөвшөөрөл авч гүйцэтгэх.

11.3. Төмөр зам дагуу хатсан өвс ургамлыг цэвэрлэх аргад техник технологийн шинэлэг хэрэгсэл ашиглах, дэвшилтэд арга /байгаль экологид сөрөг нөлөөгүй ургамал ургуулахгүй байх бодис, бусад материал, техник гэх мэт/ ажиллагааг хэрэглэх.

11.4 Ой хээрийн болон объектын галын аюулаас урьдчилан сэргийлэх, түймрээс хамгаалах, аюулгүй байдлыг хангах талаар жил бүрийн хавар (03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл), намар (09 дүгээр сарын 20-ны өдрөөс хэлэн 11 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл)-ын улирлын хугацааг түймрийн аюултай үе гэж үзэн хуурайшилтын улиралд хамгаалалтын шороон зурвас татах, хуучин зурвас газрыг сэргээх арга хэмжээг авч ажиллана.

11.5. Цахилгааны болон холбооны модон шонгийн доор хуримтлагдсан хазаар өвс, шатах материалыг хавар, намрын хуурайшилтын улирал эхлэхээс өмнө 2 метр радиуст цэвэрлэж аюулгүй болгох, ой түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах зориулалттай усан сан, худгийн тоо, хүчин чадлыг нэмэгдүүлэх.

11.6. Галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийлгэх, цаашид жил бүр тодотгол өөрчлөлтийг хийж баталгаажуулан, орон нутгийн Онцгой байдлын албанд тайлан мэдээг танилцуулж, дүгнэлт гаргуулж авах.

11.7. Гал гарах аюул эрсдэлийг үнэлэн 2023-2025 онуудад галын галт тэрэг бүхий анги, хэсэг ажиллуулах судалгаа тооцоог хийж, цаашид үе шаттайгаар ажил эхлүүлэх.

11.8. Галын галт тэрэг дуудлагаар ажиллах хэсэглэл, километр зуутыг тодорхой болгож, шинээр урд чиглэлд тавигдах замд ажиллах хил хязгаарыг зурагжуулан тогтоох.

11.9. Барилга байгууламжид ашиглагдаж байгаа барилгын материалын зардлыг тооцохдоо итгэмжлэгдсэн лабораторийн дүгнэлттэй гал тэсвэртэй зэрэглэл өндөр стандартын ШҮ - шатдаггүй, Ш - шатдаг ангиллын Ш1 - бага зэрэг шатдаг ангилалд хамаарах материалаар тооцож, төсөвт тусгаж ажиллах.

Арван хоёр. Салбар нэгжийн дарга нарын үүрэг:

12.1. Үйлдвэр, салбар нэгжүүд технологийн болон барилга байгууламжийн онцлогийг харгалзан галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулгүй байдал хангах талаар Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан Галын аюулгүй байдлын үндсэн дүрмийн дагуу "Галын аюулгүй байдлын дотоод заавар" боловсруулан ОБЕГ-аар батлуулж, мөрдөж, ажилтнуудаа танилцуулан хэрэгжүүлэх.

12.2. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.11 заалтын дагуу алслагдсан өртөө, зөрлөгт байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа салбар нэгжийн ажилчдыг хамруулан өртөө, зөрлөгийн дарга, мастераар ахлуулан галын бүлгэмийг томилгоожуулж, өдөр, шөнийн цагаар ажиллах хувилбартай, зарлан мэдээлэл дамжуулах схем, гамшиг, осол, гал түймрийн үед ажиллах техник хэрэгсэл, авах арга хэмжээг тодорхой төлөвлөх.

12.3. Салбар нэгж, цех, тасгууд жил бүр галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг хангаж, тайланг баримтжуулж

ажиллах ба галын бүлгэмийг хариуцах инженер техникийн ажилтныг даргын тушаалаар томилж, үйл ажиллагааг тогтмолжуулах.

12.4. "Төмөр замын объект ба хөдлөх бүрэлдэхүүнийг гал унтраах анхан шатны багаж хэрэгслээр хангах норм", "Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS 5566:2020 стандарт"-ыг баримтлан гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг бэлтгэж, турших, ашиглах бэлэн байдал хангаж, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17.3 заалтын дагуу аж ахуйн нэгж, байгууллагын барилга байгууламж, объект бүр нь галын аюулгүй байдал, гал түймрээс хамгаалах тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, хянан бүртгэлжүүлж, жил бүр тодотгол хийж ажиллах.

12.5. Галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийлгэх, цаашид жил бүр тодотгол өөрчлөлтийг хийж баталгаажуулан, орон нутгийн Онцгой байдлын албанд тайлан мэдээг танилцуулж, дүгнэлт гаргуулж авах.

12.6. Ашиглалтад байгаа гал унтраах дотор болон гаднах даралтат усны цэг, гидрант, гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, гал түймэр илрүүлэх мэдээлэх дохиоллын систем, гал унтраах автомат төхөөрөмж зэргийг өмчийн картад бүртгэж, тодорхой ажилтанд хариуцуулах.

12.7. Жил бүрийн хавар 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10 хүртэл, намар 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10 хүртэл өөрийн байршил харьяалсан бүс нутагт ажил үйлчилгээ явуулж байгаа газруудад ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж, ажилтнуудад нэмэлт зааварчилгаа өгч хэвших.

12.8. Байгууллагын гал унтраах багаж хэрэгсэл, гал унтраах дотор усан хангамж, гадна 50 метрийн орчимд байгаа галын гидрант, гүнгийн худгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж цэвэрлэгээ үйлчилгээ хийж, ашиглалтад бэлэн байдлыг ханга. Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны харьяа анги, салбарын дарга нар өөрийн хариуцсан объектын гал унтраах усан хангамжийн бэлэн байдлыг харьяа орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтсийн Гал түймэр унтраах, аврах анги болон төмөр замын аж ахуй нэгж, байгууллагын дарга нар хамтарч жилд 2-оос доошгүй удаа /хавар, намрын улиралд/ шалгаж, дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчлийг арилгаж, бэлэн байдлыг хангуулах.

12.9. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 заалтын дагуу салбар нэгжид ерөнхий зохион байгуулалтыг хангаж, галын аюулаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлыг тухайн салбарын ерөнхий инженер, ерөнхий инженергүй бол орлогч даргыг тушаалаар томилон хариуцна.

12.10. Энэхүү тушаалын 8.1 заалтын дагуу салбар нэгжийн харъяа барилга байгууламж, хөдлөх бүрэлдэхүүнд Галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм, норматив баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах шаардлагыг дагуу шаардагдах төсөв захиран зарцуулах эрхийг салбар нэгжийн төсөв захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан хариуцна.

12.11. Алба, хэлтэс, төв, салбар нэгжийн дарга, удирдлага, инженер техникийн ажилчид сар бүрийн нормативыг гүйцэтгэхдээ галын аюулгүй байдлыг тодорхойлсон стандарт, норм, дүрэм болон цахилгааны аюулгүй байдлын

шаардлагыг дагаж мөрдөж ажиллаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулж, галын аюулгүй байдлыг хангах талаар анхаарч ажиллах.

12.12. Ой хээрийн болон объектын гал түймэр унтраах багаж хэрэгслийг Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоол, MNS 5566:2020 стандарт норматив, энэхүү тушаалын хавсралтад заагдсаны дагуу бүрдүүлж, шалгаж, ашиглалтын бэлэн байдлыг хангуулах.

12.13. Ажилтнуудыг гал унтраах анхан шатны багаж хэрэгслийг ажиллуулах дадлага, чадвартай болгох, гал түймэр унтраах арга, техникийн ажиллагаанд сургаж дадлагажуулах сургалтын ажлыг энэхүү тушаалын 7 дугаар хавсралтад заасан сургалтын хөтөлбөрт багтаан байгууллагын удирдлага, салбар нэгжийн дарга, ерөнхий инженер, тушаалаар томилогдсон галын аюулгүй асуудал хариуцсан ажилтан, орон нутгийн мэргэжлийн байгууллага болон Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын анги салбаруудтай хамтран жил бүр зохион байгуулж, ажилтнууд өөрсдийн ажлын орчин, ахуйн хүрээнд болзошгүй галын түймрийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх мэдлэгийг тогтмол дээшлүүлэн ажиллах.

12.14. Галын аюулгүй байдлын тухай хууль, Ойн тухай хууль болон бусад нийцүүлэн гаргасан хууль дүрмийн мэдлэгийг дээшлүүлэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх 10-аас доошгүй цагийн сургалт зохион байгуулж, гал унтраах үйл ажиллагаанд дадлагажуулан, жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдрөөс өмнө шалгалт, шүүлэг авч, үр дүнг тооцсон байх.

12.15. Байгууллага, аж ахуйн нэгжүүдийн эзэмшил, зурвас газарт галын аюулгүй байдлыг хангах бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хавар, намрын хуурайшилтын улиралд хатсан өвс, ургамлыг хадах, цэвэрлэх, зайлуулах ажлыг өөрсдийн хүчээр хийх.

12.16. Салбар төмөр зам дагуу ургаж, хатсан өвс ургамлыг эзэмшигч иргэн, хуулийн этгээдээр цэвэрлүүлэх арга хэмжээг авч ажиллах.

12.17. Барилга байгууламжийн цахилгааны тоног төхөөрөмж, шугам сүлжээний угсралтыг цахилгаан байгууламжийн дүрэм, цахилгааны угсралт, ашиглалтын техникийн шаардлага, дүрмийг мөрдөж угсралт хийх ба байгууллагын удирдлага тухайн үйлчилгээг хийхэд шаардагдах зардлыг тооцож, цахилгаанчин, мэргэжлийн байгууллагууд гүйцэтгэж байх.

Арван гурав. Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын алба, анги салаан даргын үүрэг:

13.1. Галын техник сургалтын вагон шугам замд ажиллах үед Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны харъяа анги, салааны дарга, галын байцаагч нар онол, дадлагын сургалтыг зохион явуулж байх. Вагоны гал унтраагуур цэнэглэх цехийн үйл ажиллагааны ашгийн 40 хувийг уг вагон, цехийн материаллаг баазыг бэхжүүлэх, сургалт сурталчилгаанд ашиглах зорилгоор зарцуулах.

13.2. Гамшиг осол галын аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг замын хэмжээнд зохион явуулах, гарсан гал түймрийг цаг алдалгүй богино хугацаанд унтраах, гал унтраах техник хэрэгсэл, галын галт тэрэг, хүн хүч зэргийг байнгын бэлэн байлгах.

13.3. Үйлдвэр, аж ахуйн нэгжийн гамшиг осол, гал түймэртэй тэмцэх инженер техникийн комисс, галын бүлгэмийн ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах, явуулж буй ажилд туслах, шугам зам, зангилаадад ухуулга сурталчилгааг тогтмол зохиох.

13.4. Төмөр замын тээвэрт гологдол, осол, сүйрэл, гал түймэр гаргаж болзошгүй, гаргасан байгууллага, иргэдийн үйл ажиллагааг хэсэгчлэн болон бүрэн зогсоох талаар Гал түймрийн улсын хяналтын байцаагчид мэдэгдэж, Галын аюулгүй байдлын тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авахуулж ажиллах.

13.5. Хууль тогтоомжид заасны дагуу гарсан гал түймэр, галын эх үүсвэр дээр Цагдаагийн болон Онцгой байдлын газар, хэлтэст мэдэгдэж хэрэг бүртгэлт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хуулийн байгууллага болон Замын гал түймэртэй тэмцэх комисст мэдээ мэдээлэл өгч шийдвэрлүүлэх, мэдээллийн сан бий болгох.

13.6. Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албаны дарга, орлогч дарга, ахлах байцаагч, Цэрэгжүүлсэн хамгаалалтын анги, салаан дарга нарын зүгээс хийгдсэн галын аюулаас урьдчилан сэргийлэх (ГАУС) үзлэг шалгалтыг эрчимжүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, хууль дүрэм, заавар, тушаал, цахилгаанаар өгсөн үүрэг даалгавар, зөрчил арилгуулахаар өгсөн заавал биелүүлэх албан шаардлага, мэдэгдлийн заалт нэг бүрийг бүрэн биелүүлээгүй, гарсан зөрчлийг дахин давтан гаргасан, гал түймэр, галын үүсвэр гаргасан ажилтан албан хаагч нарт Галын аюулгүй байдлын тухай хууль, Ойн тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Зөрчлийн тухай хуулийн заалтын дагуу холбогдох арга хэмжээг авахуулахаар гэрээт Гал түймрийн улсын хяналтын ахлах байцаагч нар, Тээврийн хяналтын алба болон Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын албанд уламжлан шийдвэрлүүлэх.

13.7. Энэхүү тушаалын 7 дугаар хавсралтад заасан сургалтын хөтөлбөрт багтаан Замын гал түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөний дагуу Ерөнхий инженерийн шийдвэр гаргуулж гал, гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, бэлэн байдлыг хангах чиглэлээр мэдлэг олгох удирдах ажилтны болон чиглэл мэргэжлийн алба хаагч нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх танхим болон биет байдлын дадлага сургалтыг жил бүрийн 1 дүгээр улиралд төлөвлөн мэргэжлийн байгууллагатай хамтарч Цэрэгжүүлсэн хамгаалалт, онцгой байдлын алба хариуцан төсөв зардлыг нь тооцон удирдамж, төлөвлөгөө батлуулж Замын удирдлагаар шийдвэрлүүлэн сургалт зохион байгуулах.

Арван дөрөв. Гал түймрийн судалгааг зохион байгуулах журам.

Гал түймрийн хэрэг, зөрчлийг шалган, гарсан үр дүнг акт үйлдэж, материалд дараах бүрдлийг хангана. Үүнд:

1. Комиссын бүрэлдэхүүн.

- Гал түймрийн хэрэг зөрчилд хохирол учраагүй бол салбар нэгжийн дарга нар
- Гал түймрийн хэрэг зөрчилд хохирол учирсан бол алба, хэлтэс, төвийн дарга нар

- ЦХОБА-ны анги, салааны дарга нар
- Тухайн салбар нэгжийн ДС, мастер, ИТА нар
- Байлцсан иргэн, хуулийн этгээдийн хариуцсан ажилтан

2. Гал түймрийн улмаар үүссэн нөхцөл байдал, гал түймэрт өртсөн объектын товч тодорхойлолт, шалгасан акт, гэрэл зураг.
3. Гал унтраахад оролцсон байгууллага, хүн хүч.

- Гал түймэр унтраасан тухай нотломж /гал унтраах ажлын удирдагч, иргэн хуулийн этгээдийн тайлбар, тодорхойлолт, бусад нотлох баримт/

4. Гал түймрийн улмаас учирсан хохирол.

- Байгууллагын тогтоосон урьдчилсан хохирол, үнэлгээ
- Эрх бүхий үнэлгээний байгуулагаар тогтоосон хохирлын үнэлгээ

5. Гал түймрийн шалтгаан.

- Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн Гал түймэр гарсан тухай акт,
- Галын шинжээчийн дүгнэлт
- Гамшиг судлалын хүрээлэнгийн шинжээчийн дүгнэлт

6. Тухай байгууллагын галын аюулгүй байдал асуудал хариуцсан албан тушаалтан:

- Салбар нэгжийн галын бүлгэм томилсон тушаал
- Тухайн өдрийн ээлжийн ажлын томилгоо, хуваарь
- Галын аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын материал.

7. Цаашид авч хэрэгжүүлэх ажлын санал.
8. Актад дараах зүйлийг хавсаргана. Үүнд:

- Гал түймэр гарсан шууд (техникийн) шалтгааны талаарх ИТА-ны тодорхойлолт.
- Ачаатай вагон (чингэлэг) -д гал гарсан тохиолдолд учирсан хохирлын тооцоог гаргасан тодорхойлолт, комиссын баталгаажуулсан акт, холбогдох эх баримтууд.
- Гал түймрийн дараа суурин байгууламж, хөдлөх бүрэлдэхүүний нөхцөл байдлын талаарх техникийн акт.
- Тухайн нутаг дэвсгэрт гал түймэр гарсан өдрийн цаг агаарын нөхцөл байдлын тухай Ус, цаг уурын албаны мэдээ.

Арван тав. Гал түймэр гарсан хурлын тэмдэглэл

15.1. Гал түймрийн хэрэг зөрчилд хохирол учраагүй бол салбар нэгжийн дарга нарын удирдлага доор хурал зохион байгуулж, гарсан шийдвэрийг материалжуулан комиссын нарийн бичгийн даргад ирүүлэх.

15.2. Гал түймрийн хэрэг зөрчилд хохирол учирсан бол алба, хэлтэс, төвийн дарга нарын удирдлага доор хурал зохион байгуулж, гарсан шийдвэрийг материалжуулан комиссын нарийн бичгийн даргад ирүүлэх.

15.3. Гал түймрийн хэрэг зөрчилд хохирол учирсан, хүн нэрвэгдсэн тохиолдолд хариуцсан Замын орлогч даргын удирдлага доор хурлыг зохион байгуулж гарсан шийдвэрийг комиссын нарын бичгийн даргад ирүүлэх.

15.4. Гал түймрийн хэрэг зөрчилд хохирол учирсан, хэд хэдэн салбар нэгж, олон хүн нэрвэгдсэн тохиолдолд Замын ерөнхий инженерийн удирдлага доор хурал зохион байгуулж шийдвэр гаргаж ажиллана.

-o0o-

"УБТЗ" ХНН-ийн даргын 2023 оны .09 дугаар
сарын .11.-ны өдрийн .....А/802..... дугаар
тушаалын 4 дүгээр хавсралт

ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам" /цаашид "Нийгэмлэг" гэх/ -ийн алба, төв, хэлтэс, тасаг, салбар, нэгж /цаашид "алба, салбар, нэгж" гэх/-д төлбөртэй үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь энэхүү журмаар зохицуулагдана.

Хоёр. Галын галт тэрэг, галын авто машин ашиглах үед төлбөр тооцох аргачлал

2.1. Галын галт тэрэг, галын автомашин ашигласан тохиолдолд дараах аргачлалаар тооцно.

2.2. Гал унтраах нэг тасгийн хүн хүч, тэдгээрийн цалингийн тооцоо

$$X = (X_1 + X_2 + X_3 + X_4 + \ldots\ldots\ldots\ldots X_n) \times N$$

Энд: X_1 – ЦХА-ийн дарга

X_2 – ГУАУ-ийн нэг цагийн үнэлгээ

X_3 – Жолоочийн нэг цагийн үнэлгээ

X_4 - Гал сөнөөгч нарын нэг цагийн үнэлгээг гал унтраахад оролцон гал сөнөөгчийн тоогоор үржүүлж тооцно..

N– Гал дээр ажилласан нийт цаг.

Гал унтраахад оролцсон тухайн ажилтны нэг цагийн хөлсийг дараах томьёогоор бодно.

$$X = /Y + Ш + \frac{Y \times У}{100\%}/ : 21:8$$

Y – Үндсэн цалин төгрөгөөр

Ш – Ажилтны шагналт цалин 50%

У – Тухайн ажилтны удаан жилийн нэмэгдэл, хувиар

21 – сард ажиллах дундаж хоног

8 – 1 өдрийн ажлын цаг

Ж нь : Ангийн даргын нэг цагийн үнэлгээг бодож гаргая,

У = 0 гэж үзвэл

$$X_1 = /Y_1 + Ш + \frac{Y_1 \times У}{100\%}/:21:8 = /100900+50450+ \frac{100900 \times 0}{100}/:21:8 = 151350:21:8 = 901$$ төг гэх мэт.

Бусад албан тушаалтны цагийн хөлсийг бодож ажилтнуудын бүх цалингийн нийлбэр Х-ийг олоод гал дээр ажилласан цаг N-ээр үржүүлж бодно.

Гурав. Төлбөр тооцоо

3.1. Гал унтраахад хэрэглэгдсэн бодис материал болон холбогдох бусад зардлыг тухайн орон нутгийн жишиг үнээр нэхэмжилж авна.

3.2. Гал унтраахад ашиглагдсан ГАМ, тоног төхөөрөмж элэгдлийн зардлыг тооцохдоо тухайн авто машины үнийг 0,001 коэффициентоор үржүүлж тооцно.

3.3. Шөнийн болон нийтийн, амралтын өдөр гал унтраасан тохиолдолд ажлын бүх хөлсийг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу 1,5 түүнээс дээш нэмэгдүүлж тооцно.

3.4 Энэхүү тушаалын 4 дүгээр хавсралтад тусгагдсан үнэ, тарифын дагуу "УБТЗ" ХНН-ийн харъяа салбар нэгжтэй тухайн сардаа тооцоо хийнэ.

3.5. Гадны байгууллагад нэмэлтээр үйлчилгээ үзүүлэх тохиолдолд 4 дүгээр хавсралтад тусгагдсан үнэлгээг 2 дахин нэмэгдүүлэн тооцно.

- oOo -

"УБТЗ" ХНН-ийн даргын 2023 оны .09. дугаар
сарын ..11..-ны өдрийн .....А/802..... дугаар
тушаалын 5 дугаар хавсралт

ТӨЛБӨРТ ҮЙЛЧИЛГЭЭ ХИЙХ ҮНЭ ТАРИФ

(Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 9 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэн боловсруулав.)

Д/Д	Төлбөрт үйлчилгээний нэр төрөл	Үнэ,тариф /төгрөг/	Тайлбар
1	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтээр ахуйн осол, эрсдэлээс сэргийлэх, аврах, хамгаалах, хор уршгийг арилгах ажил гүйцэтгэх	50.000	Ахуйн эрсдэлд ажиллах 1 цагийн хөлс
2	Ус соруулах, ус цацах ажилд тусгай зориулалтын машин техник гаргах	70.000	1 мото/цаг тутамд
3	Объектын болон автомашин, техникийн гал унтраагуур цэнэглэх	——	Батлагдсан үнээр
4	Зориулалтыг нь өөрчлөн ашиглах барилга байгууламжийн галын аюулгүй байдалд зөвлөмж өгөх	25.000	1 удаа
5	Аврах болон гал унтраах багаж хэрэгслийг турших, засвар үйлчилгээ, тохируулга хийх	25.000	1 удаа
6	Бодис материал хэрэгслийн галын аюулын шинж чанарыг тодорхойлох	25.000	1 удаа
7	Гал эсэргүүцэх зай хэмжээ, галын аюултай үйлдвэрийн ангилал тогтоох	25.000	1 удаа
8	Баг, хамгаалах хувцас, хянах, хэмжих багаж хэрэгслийн ажиллагааг шалгах	25.000	1 удаа
9	Онцгой аюул эрсдэл үүссэн тохиолдолд орон сууц, барилга, машин техникийн хаалга, цонх цоож түгжээ онгойлгох	50.000	1 удаа
10	Урлаг, спорт, шоу тоглолтын арга хэмжээнд хамгаалалт гаргах	200.000	Тасаг хүртэлх нэгж 1 цаг ажиллуулахад
11	Гал унтраах зориулалтаас бусад тохиолдолд галын галт тэрэг, галын автомашин ашиглах	100.000	Тасаг хүртэлх нэгж 1 цаг ажиллуулахад
12	Байгууллага аж ахуйн нэгжийн хүсэлтээр галын аюулаас урьдчилан сэргийлэх сэдвээр семинар, үзүүлэх сургууль, лекц яриа хийх, хичээл заах, мэргэжлийн зөвлөгөө, зөвлөмж өгөх	50.000	10 хүртэл хүнд
		80.000	25 хүртэл хүнд
		100.000	50 хүртэл хүнд

- oOo -

"УБТЗ" ХНН-ийн даргын 2023 оны ..09 дугаар
сарын ..11..-ны өдрийн .....А/802..... дугаар
тушаалын 6 дугаар хавсралт

АЛСЛАГДСАН ӨРТӨӨ ЗӨРЛӨГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ОЙ, ХЭЭРИЙН БОЛОН ОБЪЕКТЫН ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ БАГАЖ, ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

(Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэв)

№	Өртөө зөрлөгийн Нэр	Түймэр гарах эрсдэл бүхий өртөө, зөрлөг	Шаардагдах багаж хэрэгсэл (тоо)									
			Холбооны хэрэгсэл	Улээгч аппарат	Ус шуршигч	Усны сав /1500л-ээс доошгүй багтаамжтай/ зөөвөрлөх чиргүүлийн хамт	Цуравдагч аппарат	Усны сав зөөвөрлөх зориулалттай авто чиргүүл	Ус шахах насос 11л/с доошгүй даралттай, даралтын хоолой 60м доошгүй /3ширхэг/ Кранттай хушуу 1 ширхэг	Моторт хөрөө	Галд тэсвэртэй хувцас /цамц, өмд, бээлий, малгай, гутал/	Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл
1	Сүхбаатар өртөө	4	4	12	40	4	8	3	3	8	32	12
2	Дархан өртөө	6	6	18	60	6	12	2	2	12	48	18
3	Салхит өртөө	2	2	6	20	2	4	2	2	4	16	16
4	Эрдэнэт өртөө	4	4	12	40	4	8	4	4	8	32	12
5	Зүүнхараа өртөө	6	6	18	60	6	12	3	3	12	48	18
6	Толгойт өртөө	6	6	18	60	6	12	4	4	12	48	18
7	Улаанбаатар өртөө	17	17	51	170	17	34	9	9	34	136	51
9	Багануур өртөө	2	2	6	20	2	4	2	2	4	16	16
10	Чойр өртөө	5	5	15	50	5	10	8	8	10	40	15
11	Сайншанд өртөө	5	5	15	50	5	10	6	6	10	40	15
11	Замын-Үүд өртөө	4	4	12	40	4	8	7	7	8	32	12
12	Баянтүмэн тасаг	5	5	15	50	5	10	6	6	10	40	15
Бүгд		**55**	**55**	**171**	**570**	**55**	**114**	**56**	**56**	**114**	**456**	**69**

ЗАМЫН АНГИ, ХЭСГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ОЙ, ХЭЭРИЙН БОЛОН ОБЪЕКТЫН ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ БАГАЖ, ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

(Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг үндэслэв)

№	Замын анги хэсгийн нэр	Түймэр гарах эрсдэл бүхий замын анги хэсэг		Шаардагдах багаж хэрэгсэл (тоо)									
			Холбооны хэрэгсэл	Улаагч аппарат	Ус шуршигч	Усны сав \ 1000л-ээс доошгүй багтаамжтай\, зөөвөрлөх чиргүүлийн хамт	Усны сав зөөвөрлөх авто чиргүүл	Ус шахах насос 11 л/с доошгүй даралттай, даралтын хоолой 60м доошгүй /3ширхэг/ Кранттай хушуу 1 ширхэг	20 л багтаамжтай усны сав	Цуравдагч аппарат	Моторт хөрөө	Гагд тэсвэртэй хувцас \ цамц, өмд, бээлий, малгай, гутал \	Эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл
1	Замын 1-р анги	15	15	45	75	15	10	10	30	30	30	120	75
2	Замын 2-р анги	21	21	63	105	21	17	17	51	42	42	168	105
3	Замын 3-р анги	13	13	41	65	26	9	9	27	26	-	104	39
4	Замын 3-р анги	13	13	41	65	26	9	9	27	26	-	104	39
5	Замын 5-р анги	8	15	53	150	23	6	6	18	30	8	106	37
6	Замын 6-р анги	8	15	53	150	23	5	5	15	30	8	106	37

Бусад салбар нэгжүүд:

Д/д	Багажны нэр	Нийт ажилтнуудын тоонд харьцуулсан хувиар тоог гаргана
1	Троссон шүүр	25 хувь
2	Цохиур	50 хувь
3	Маажуур	25 хувь

ОЙ ХЭЭРИЙН ТҮЙМРИЙГ УНТРААХ АЖИЛД ОРОЛЦОЖ БАЙГАА АЖИЛТНУУДЫН ХУВИЙН ХАНГАМЖИД БАЙХ ЗҮЙЛС, ЗААВАЛ ЭЗЭМШСЭН БАЙХ АРГА ТЕХНИКИЙН ЖАГСААЛТ

1. Түймрийг унтраах ажилд оролцож байгаа ажилтнуудын хувийн хангамжид дараах зүйлс байна. Үүнд:

1.1. Галд тэсвэртэй материалаар хийсэн хөнгөн дулаан хувцас.
1.2. 2Х2 метрийн хэмжээтэй бризентэн нөмрөг.
1.3. Эмийн сан.
1.4. Резинэн цохиур эсхүл бага оврын хүрз

2. Түймрийг унтраах ажилд оролцож байгаа ажилтнуудын заавал эзэмшсэн байх арга техникт дараах зүйл орно. Үүнд:

2.1. Түймрийг унтраах багаж хэрэгслийг ажиллуулах дадлага, чадвар.
2.2. Түймэр унтраах арга, техник болон хөдөлмөрийн аюулгүйн үйл ажиллагаанд суралцсан байх.
2.3. Түймэр унтраах үед түлэгдэж, гэмтсэн хүмүүст эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх чадвартай байх

- oOo -

АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГА, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИД ГАЛ УНТРААХ АНХАН ШАТНЫ БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЗАЙЛШГҮЙ БАЙХ ШААРДЛАГА НОРМ MNS 5566:2020

MNS 5566:2020 стандартын 5 дахь заалт: Анхан шатны багаж хэрэгсэлд гал түймэр үүсвэрлэн гарсан эхний үед шаталтыг хязгаарлах зориулалтаар хэрэглэх дараах төрлийн багаж хэрэгсэл багтана.Үүнд:

Барилга байгууламжид:

1. Хүрз
2. Галын дэгээ
3. Хөрөө
4. Сүх
5. Царил
6. Хувин (конус хэлбэртэй)
7. Жоотуу
8. Элстэй сав (хайрцаг) 0,5м^3 багтаамжтай. Хүн өргөөд явах боломжтой савласан эсвэл ууталсан байж болно.
9. Галд тэсвэртэй бүтээлэг
10. Төрөл бүрийн гал унтраагуур
11. Агаар дахь тэсрэх болон галын аюултай хольцыг саармагжуулах бодис бүхий хэрэгсэл
12. Бусад /саармагжуулагч бодис, усан сан, ус сорох, шахах хөөрөг, галын хоолой, хушуу гэх мэт/

MNS 5566:2020 стандартын 8.8 дахь заалт: Галын саравчинд хамгаалж буй объектын галын аюулын байдал, талбайн хэмжээнээс хамааруулан сүх, хүрз, дэгээ, хувин, царил, элстэй сав (0,5м^3 багтаамжтай), тус бүр 1 ширхэг, галд тэсвэртэй бүтээлэг (1х1-2х2м^2 хэмжээтэй) тус бүр 2 ширхгээс багагүй байлгана.

- oOo -

МОНГОЛ - ОРОСЫН ХУВЬ
НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ

ОБЪЕКТЫН БОЛОН ОЙ, ХЭЭРИЙН ГАЛ УНТРААХ АНХАН ШАТНЫ БАГАЖ ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ХЯНАЛТЫН КАРТ

ГАЛ УНТРААХ АНХАН ШАТНЫ БАГАЖ ХЭРЭГСЛИЙН ЗАЙЛШГҮЙ БАЙХ НЭГ ИЖ БҮРДЛИЙН ЖАГСААЛТ
/MNS 5566:2020, ЗГ-ын 106, 339-р тогтоол, "УБТЗ" ХНН-ийн А-....-р тушаал/

д/д	Багаж хэрэгслийн нэр		Заагдсан тоо / ширхэг /
1.	Хүрз	Хүрз (хумбан)	1 ш – ээс багагүй
		Хүрз (дөрвөлжин)	1 ш – ээс багагүй
		Бага оврын хүрз	Хүн тус бүр
2.	Галын дэгээ	Багор	1 ш – ээс багагүй
		Модон бариултай дэгээ	1 ш – ээс багагүй
3.	Хөрөө	Хөрөө	
		Моторт хөрөө	
4.	Өвсний сэрээ		
5.	Сүх		1 ш – ээс багагүй
6.	Царил		1 ш – ээс багагүй
7.	Хувин / конус хэлбэртэй /		1 ш – ээс багагүй
8.	Жоотуу		
9.	Резинэн цохиур		Хүн тус бүр
10.	Троссон шүүр		Хүн тус бүр
11.	Элстэй сав /хайрцаг/ 0,5м^3 багтаамжтай. Хүн өргөөд явах боломжтой савласан эсвэл ууталсан байж болно.		1 ш – ээс багагүй
12.	Галд тэсвэртэй бүтээлэг	1мх1м	2ш-ээс багагүй
		2мх2м	2ш-ээс багагүй
	Брезинтэн нөмрөг	2мх2м	Хүн тус бүр

13.	Цахилгаан утас огтлох хайч, резин гутал, дэвсгэр		
14.	Галд тэсвэртэй хувцас / цамц, өмд, бээлий, малгай гутал /		Хүн тус бүр
15.	Төрэл бүрийн гал унтраагуур /талбайн м^2 хэмжээнээс хамаарч байрлуулах /	Нунтаг 5кг	80 м^2 тутамд
		Нунтаг 20 кг	80 м^2 тутамд
		Хөөс	
		Шингэн / Сотериа /	80 м^2 тутамд
		Хийн	80 м^2 тутамд
16.	Үлээгч аппарат		
17.	Цуравдагч аппарат		
18.	Бусад / саармагжуулагч бодис, усан сан, ус сорох, шахах хөөрөг, галын хоолой, хушуу гэх мэт /	Ус шүршигч	
		51мм диаметртэй 18-20м урт хоолой	
		Сорох шахах хөөрөг	
		Хушуу	
19.	Агаар дахь тэсрэх болон галын аюултай хольцыг саармагжуулах бодис бүхий хэрэгсэл		
20.	Жижиг тэргэнцэр, чиргүүл		
21.	Усны сав	1500 л дээш	
		200л	
		20л	
22.	Дулааны үйлчлэлээс хамгаалах 1,4мх2,0м хэмжээтэй хаалт		
23.	Дулааны үйлчлэлээс хамгаалах хаалтны тулгуур, суурь		
24.	Холбооны хэрэгсэл		

Байгууллагын нэр:.....
.....

Багаж хэрэгслийн нэр төрөл дугаар:
.....

Огноо:.....

Сар	Чанар байдлын тэмдэглэл	Шалгасан албан тушаалтаны гарын үсэг
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII		
VIII		
IX		
X		
XI		
XII		

Байгууллагын нэр:.....
.....

Багаж хэрэгслийн нэр төрөл дугаар:
.....

Огноо:.....

Сар	Чанар байдлын тэмдэглэл	Шалгасан албан тушаалтаны гарын үсэг
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII		
VIII		
IX		
X		
XI		
XII		

Байгууллагын нэр:.....
.....

Багаж хэрэгслийн нэр төрөл дугаар:
.....

Огноо:.....

Сар	Чанар байдлын тэмдэглэл	Шалгасан албан тушаалтаны гарын үсэг
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII		
VIII		
IX		
X		
XI		
XII		

Байгууллагын нэр:.....
.....

Багаж хэрэгслийн нэр төрөл дугаар:
.....

Огноо:.....

Сар	Чанар байдлын тэмдэглэл	Шалгасан албан тушаалтаны гарын үсэг
I		
II		
III		
IV		
V		
VI		
VII		
VIII		
IX		
X		
XI		
XII		

"УБТЗ" ХНН-ийн даргын 2023 оны 09 дугаар
сарын 11-ны өдрийн А/202 дугаар
тушаалын 7 дугаар хавсралт

АЛБА, ХЭЛТЭС, ТӨВ, САЛБАР НЭГЖИЙН АЖИЛТНЫ ГАЛЫН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ЭЗЭМШВЭЛ ЗОХИХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Алба, хэлтэс, төв, салбар, нэгжид гамшгаас хамгаалах, галын аюулгүй байдлыг хангах, үүргээ биелүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх, ИТА, ажилтан, алба хаагч нарын мэдлэгийг дээшлүүлэх, бэлэн байдлыг хангуулахаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

Нэг. Гамшиг, осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтын хөтөлбөрийн дагуу өвөл цагийн техникийн сургалтыг жилийн төлөвлөгөөнд тусгаж, удирдах албан тушаалтан, ажилтан албан хаагч гэсэн ангиллаар бүх алба хэлтэс, төв, салбар нэгжийн удирдлагууд байгууллагын хэмжээнд сургалт зохион байгуулж ажиллах.

Хоёр. Сургалтыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 34.2.4, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 17 дугаар зүйлийн 17.2.4 заалтуудын дагуу удирдах албан тушаалтан, ажилтан, алба хаагчийг гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ ОБЕГ-ын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А-130 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалын дагуу ангиллын сургалтыг "Хууль эрх зүйн акт", "Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө", "Гал унтраах шуурхай төлөвлөгөө, карт", "Гамшгийн төрлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах", "Гамшгаас хамгаалах удирдлага, зохион байгуулалт, штабын бэлтгэл" чиглэлээр удирдах албан тушаалтны сургалтыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж явуулах.

Гурав. Ажилтан албан хаагч нарын сургалтыг жилд 2-оос доошгүй удаа "Гамшиг, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны тухай", "Гамшиг, гал түймрийн эрсдэлийг бууруулах арга зам", "Амилуулах суурь тусламж", "Гамшгаас хамгаалах төлөвлөлт, гал унтраах шуурхай төлөвлөгөө, карт, байгууллагын гамшгаас хамгаалах ажиллагаанд ажилтан, алба хаагчдын оролцоо, гүйцэтгэх үүрэг" зэрэг гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх дараах чиглэлээр хичээлийн хөтөлбөр сэдвийн дагуу бүрэн хамруулж байгууллагын удирдлага хариуцан зохион байгуулах. Үүнд:

1. Галын аюулгүй байдлын тухай хууль /2015-07-02/-ийн 3, 16, 17-р зүйл, Гамшгаас хамгаалах тухай хууль /2017-02-02/-ийн 4, 34, 37, 51-р зүйл, Ойн тухай хууль /2012-05-27/-ийн 3, 20, 44-р зүйл /сургалт 2 цаг/
2. Зөрчлийн тухай хууль /2017-05-11/-ийн 5.14-р зүйл, Засгийн газрын 2016 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм"-ийн 2, 3, 4, 5 дугаар заалт, /2017-12-12/ А-485 тоот тушаал, болон бусад эрх зүйн акт, цахилгаан, сэрэмжлүүлгийг танилцуулж, судлуулах /сургалт 2 цаг/
3. Салбар, нэгжид ашиглагдаж байгаа гал унтраагуурын хүчин чадал, хадгалах, ашиглах журам, гал унтраах дотуур, гадуур усан хангамжийг ашиглах

тэдгээрийг шалгаж бэлэн байдлыг хангах ажиллагаа, MNS 55:66-2020 стандартад заагдсан гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн төрөл, ашиглах зориулалт, эзэмших арга /дадлага 1 цаг/

4. Цахилгаан эрчим хүч, тоног төхөөрөмжийн угсралт, ашиглалтын дүрмийг мөрдөж ажиллах сургалтыг мэргэжлийн байгуулллагатай хамтран зохион байгуулах цахилгаанаас шалтгаалсан гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай сургалт /1 цагаас доошгүй/

5. Төрөл бүрийн нөхцөлд гал түймэр гарсан үед авах анхан шатны арга хэмжээ, унтраах арга зүй, түлэгдэлт, бэртэл гэмтлийн үед эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, амилуулах суурь тусламж үзүүлэх чадвар олгох /дадлага 2 цаг/

6. Байгууллагын технологи үйл ажиллагаа, онцлогт шаардагдсан галын аюулгүйн норм, дүрэм, стандарт зэргийг үйл ажиллагааны онцлогт тохируулан сургалтын хөтөлбөрт оруулж, гамшгаас хамгаалах төлөвлөгөө, гал унтраах шуурхай төлөвлөгөө, картын дагуу сургууль дадлага хийж, сургалт явуулах. /сургалт 2 цаг/

Дөрөв. Дээрх сургалтын цаг сэдэвтэй холбогдуулан төрийн болон төрийн бус байгууллага, "УБТЗ" ХНН-ийн бусад мэргэжлийн байгууллагад тухайн цаг сэдэвтэй холбогдсон хүсэлт гарган сургалт авах.

Тав. Сургалтын чанар үр дүнг жил бүрийн 03 дугаар сарын 20-ны дотор шалгалт авч, үнэлэлт өгч баримтжуулан ажилла.

- oOo -